



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар
Анагаах ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: “Сувилахуй” дипломын сургалтын хөтөлбөр

Индекс: 091301

Шинжээчийн баг:

Ахлагч: Т.Алтанцэцэг
Гишүүд: Ю.Оюунзул
Г.Шүрэнмягмар

Он сар өдөр: 2022 оны 12 сарын 1-2

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль																												
Сургалтын хөтөлбөрийн нэр	“Сувилахуй” дипломын хөтөлбөр																												
Индекс	D091301																												
Шинжээчид	<p>Ахлагч: Т.Алтанцэцэг – Хүүхдийн төв сувилал, Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал, доктор, профессор</p> <p>Гишүүд: Г.Шүрэнмягмар – Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн Сувилахуйн тэнхимийн ахлах багш Ю.Оюунзул – Хавдар судлалын үндэсний төвийн Сувилахуйн албаны дарга</p>																												
БМИУЗ-ийн мэргэжилтэн	Б.Мядагмаа Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч																												
Төлөвлөгөө	<table border="1"> <thead> <tr> <th>Он сар өдөр</th> <th>Хийгдсэн байх ажлууд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2022.11.17</td> <td>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/</td> </tr> <tr> <td>2022.11.18</td> <td>Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.</td> </tr> <tr> <td>2022.11.8</td> <td>№ A/173</td> </tr> <tr> <td></td> <td>Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан</td> </tr> <tr> <td></td> <td>Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.</td> </tr> <tr> <td></td> <td>Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан.</td> </tr> <tr> <td>2022.12.01-02</td> <td>Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан.</td> </tr> <tr> <td></td> <td>Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан</td> </tr> <tr> <td></td> <td>Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн.</td> </tr> <tr> <td></td> <td>/танхимаар/</td> </tr> <tr> <td></td> <td>Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн.</td> </tr> <tr> <td></td> <td>/онлайнаар/</td> </tr> <tr> <td>2022.12.08</td> <td>Шинжээчийн багийн тайланг ажлын албанад хүлээлгэн өгсөн.</td> </tr> </tbody> </table>	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд	2022.11.17	/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/	2022.11.18	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.	2022.11.8	№ A/173		Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан		Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.		Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан.	2022.12.01-02	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан.		Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан		Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн.		/танхимаар/		Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн.		/онлайнаар/	2022.12.08	Шинжээчийн багийн тайланг ажлын албанад хүлээлгэн өгсөн.
Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд																												
2022.11.17	/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/																												
2022.11.18	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.																												
2022.11.8	№ A/173																												
	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан																												
	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.																												
	Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан.																												
2022.12.01-02	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан.																												
	Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан																												
	Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн.																												
	/танхимаар/																												
	Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн.																												
	/онлайнаар/																												
2022.12.08	Шинжээчийн багийн тайланг ажлын албанад хүлээлгэн өгсөн.																												
Шалгуур шаардлага /журам/	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага																												

III. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол улсад 1960-аад оноос хөдөө орон нутагт бүс дундын тодотголтой тусгай мэргэжлийн сургуулиуд байгуулах шийдвэр гарсны дагуу БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1962 оны 04-р сарын 18-ны өдрийн 200-р тогтоолоор Монгол орны зүүн өмнөд хязгаарт орших Дорнговь аймгийн Сайншанд хотод зүүн бүсийн аймгуудыг эх баригч-бага эмч, сувилагчаар хангах чиг үүрэгтэй Монгол улсын эрүүл мэндийн салбарын ууган сургуулиудын нэг Анагаах ухааны дунд сургуулийн үндэс суурь тавигджээ. Тус сургууль нь 1970 онд сувилагчийн анги нээж, 7-р анги төгссөн 30 сурагчийг элсүүлэн авч 2 жил суралцуулж, үнэмлэх олгон төгсгөсөн түүхтэй.

Боловсролын сайд, ЭМСайдын хамтарсан 1991 оны 124/A44 тоот тушаалаар АУИС-ийн харьяа Анагаах ухааны коллеж, улмаар 2014 онд холбогдох тушаал, тогтоолын дагуу АШҮҮИС-ийн Дорнговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль болж өргөжсөн байна.

Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлөөр 2000 онд анх удаа, 2005 онд 2 дахь, 2018 онд 3 дахь удаагаа ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн байна.

Сувилахуйн дипломын мэргэжлийн индекс 091301, суралцагч 3 жилийн хугацаанд 106 багц цаг судалж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 091301 индекс бүхий “Сувилахуй” дипломын сургалтын хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан боловч тус хөтөлбөрт хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, оролцогч талуудаас судалгааг сүүлийн 5 жилд авч, сайжруулалт хийсэн талаар тусгагдаагүй. Тус мэргэжлийн хөтөлбөрийг албан ёсны удирдах байгууллагаар баталгаажуулаагүй.
- Сувилахуйн дипломын мэргэжлийн суралцагч нараас сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинтой холбоотой 14 багц асуулгаар маш хангалтгүй-1, хангалтгүй-2, дунд зэрэг-3, хангалттай-4, маш хангалттай-5 онооны үзүүлэлт бүхий судалгааны асуумжийн хуудсыг боловсруулан 2017, 2021 онуудад 2 удаагийн давтамжтай төгсөгч болон суралцагч нараас судалгааг авч үр дүнг тооцон гаргасан. Төгсөгчийн сэтгэл ханамжийн дундаж 2016 оны судалгаагаар 3.76, 2021 оны судалгаагаар 4.1 болж өссөн. Суралцагчийн сэтгэл ханамжийн дундаж 3.8-аас 4.02 болж өссөн үзүүлэлттэй.
- Сургалтын төлөвлөгөөг төв сургуулиас баталсны дагуу хэрэгжүүлдэг бөгөөд 2016 онд ерөнхий суурь хичээл 21 хувь, мэргэжлийн суурь хичээл 40.9 хувь, мэргшүүлэх хичээл 38.1 хувь байсныг 2020 онд БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалд уялдуулан ерөнхий суурь хичээл 25.5 хувь, мэргэжлийн суурь хичээл 21.7 хувь, мэргшүүлэх хичээл 52.8 хувь байхаар хичээлүүдийн харьцааг тооцон мэргшүүлэх хичээлийн агуулгыг нэмэгдүүлэн хөтөлбөрийн хүрээнд 110 багц цагийг хэрэгжүүлдэг.
- Зүүн болон.govийн бүсийн аймгуудын хэмжээнд ажиллаж буй нийт сувилахуйн мэргэжилтний 90 хувийг тус сургуулийн үе үеийн төгсөгчид эзэлж, ажил эрхлэлтийн хувь 91.6 хувьтай байна. Ажил олгогчийн уулзалтад оролцогч төлөөллүүдийн хэлж буйгаар сувилахуйн мэргэжилтнүүдийг тус сургуулийн төгсөгчдөөр хангадаг гэдгийг баталж байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургууль нь 60 жилийн түүхтэй сургууль бөгөөд зүүн болон.govийн бүсийн аймгуудын хэмжээнд ажиллаж буй нийт сувилахуйн мэргэжилтний 90 хувийг тус хөтөлбөрийн үе үеийн төгсөгчид эзэлж байгаа бөгөөд 60 хувь нь I шатлал, 30 хувь нь II шатлал, 10 хувь нь III шатлалын эмнэлгийн байгууллагад ажилладаг, ажил эрхлэлтийн хувь 91.6 хувь байна.
- Дотоодын ижил мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулалт хийхэд мэргшүүлэх хичээлийн хувь 52.8% буюу төрөлжсөн сувилахуйн хичээлүүд болон төгсөлтийн өмнөх дадлагын багц цагаар илүү байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход тусгасан мэдээллийн эх сурвалжуудыг тодорхой дурдаагүй.
- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагад оролцогч талуудын саналыг тусгаагүй.
- Хөтөлбөрт оролцогч талуудын хэрэгцээг судалсан судалгаа, дүн шинжилгээг сүүлийн 5 жилээр тооцож тусгаагүй зөвхөн 2 жилийн үр дүнг тооцон гаргасан
- Гадаадын ижил мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулалт хийгдээгүй.

Зөвлөмж:

- Мэргэжлийн хөтөлбөрийг хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх төгсөлтийн өмнөх бодлого зохицуулалтын газрын дарга болон салбар сургуулийн захирлаар баталгаажуулан хэрэгжүүлдэг байх
- Мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагад оролцогч талуудаас тогтмол саналыг авч сайжруулах ажлыг тогтмолжуулж, сайжруулалт хийсэн хурлын тэмдэглэл, тайлан мэдээг гаргадаг байх
- Оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд суурилан сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт сайжруулалтад салбар сургуулийн зүгээс саналаа өгдөг байх боломжийг эрэлхийлэх
- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагад сүүлийн үеийн аргуудыг ашиглан анализ хийж сайжруулдаг байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн 2016 оны “Мэргэжилтний цогц чадамж” эмхэтгэлд мэргэжлийн хөтөлбөрийн үр дүнг 10 бүлэг цогц чадамжаар тодорхойлон 63 төрлийн мэдлэг, 174 төрлийн чадвар, 62 төрлийн хандлагыг тодорхойлсон бөгөөд цогц чадамжийг “Миллерийн гурвалжин”-гийн загвар болох сонссон-I түвшин, харсан-II түвшин, мэдсэн-III түвшин, хийсэн-IV түвшин, чадсан-V түвшингээр эзэмшүүлдэг талаар тайланд тусгасан боловч үнэлсэн үнэлгээ, нотлох баримтаар гарч ирээгүй.
- Хөтөлбөрийн үр дүнгийн талаар ажил олгогчдоос 6 багц асуулгаар 2017 болон 2021 онуудад судалгаа авсан аль аль онд 3.61 сүүлийн 4 жилийн давтамжийн судалгаагаар ижил үр дүн гарсан. Мөн дээрх онуудад үйлчлүүлэгч нараас авсан судалгаагаар 3.75-аас 3.95 болж өссөн үр дүн гарсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үр дүн (PLO)-г “Сувилахуйн мэргэжлээр төгсөгчийн эзэмшсэн байх чадамж”-ийн 10 үзүүлэлтээр тодорхойлон гаргаж, цогц чадамжийг 5 түвшинд эзэмшүүлэхэд “Миллерийн гурвалжин”-ийн загварыг ашигладаг.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудаас авч буй судалгааны асуумжийг хөтөлбөрийг зорилго, үр дүн рүү чиглүүлэн боловсруулж урьдчилан туршиж үзэж, тогтмол авч үр дүнг хөтөлбөрт тусгадаг байх

Зөвлөмж:

- Мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд цаашид хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн үр дүнд суурисан сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хөтөлбөрийн сайжруулалтад тусгадаг байх
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хөтөлбөрийн үр дүнгийн нийцэл, уялдаа холбоог тодорхойлох
- Хөтөлбөрийн үр дүн болох цогц чадамжийг сувилахуйн мэргэжлийн шаталсан хэлбэрт тохируулан боловсруулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, үр чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 5-р сарын 19-ний өдрийн А/56 тоот тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургуулийн захирлын 2022 оны 4 сарын 14 өдрийн А/29 тоот тушаалаар хөтөлбөрийн дэд хороог 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 3 удаагийн хурлыг зохион байгуулсан.(Хурлын 2022 оны 4 сарын 14, 10 сарын 19, 11 сарын 1 дугаар №1,2,3 тэмдэглүүдтэй танилцсан.)
- АШУҮИС-ийн захирлын 2022 оны 10 сарын 27 өдрийн А/225 тушаалаар баталсан “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу ажиллах бөгөөд үүний дагуу салбар сургууль дээрээ хөтөлбөрийн дэд хороог байгуулсан.
- Мэргэжлийн суурь 12 хичээл, мэргэжлийн суурь 7 хичээл, мэргэшүүлэх 24 хичээл, сонгон судлах 16 хичээлийн нийт 62 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан бөгөөд хичээлийн хөтөлбөрт хичээлийн индекс, агуулгын багтаамж, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн, сургалтын нэгдмэл байдал, сэдэвчилсэн төлөвлөгөө (хичээлийн сэдэв, цогц чадамжийн харьцуулалт), хичээлийн үндсэн агуулга (хичээл удирдах төлөвлөгөө) оюутны гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх арга ба хэлбэр бүтцээр боловсруулан сайжруулалтыг АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь анагаах ухааны сургуулийн захирал, АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх төгсөлтийн өмнөх бодлого зохицуулалтын газрын даргаар баталгаажуулан хэрэгжүүлдэг.
- Сургалтын явцад лекц болон семинарын хичээлийг хөтлөх явуулахад багш бүр “Хичээл удирдах төлөвлөгөө”-г боловсруулан сургалтын албаар батлуулан хэрэгжүүлдэг бөгөөд хичээлийн явцад хийгдэх үйл ажиллагааг хугацаагаар нарийн төлөвлөн хэрэгжүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017-2022 он болох сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 116 хичээлийн хөтөлбөрийг сайжруулсан.

Анхаарах асуудал:

- Тайлангийн хавсралт хэсэгт оролцогч талуудын судалгааны асуумжийг оруулсан боловч түүнийг ашиглаж судалгааг тогтмол авч, саналыг баримт бичигт тусгасан баримт бага байгаа анхаарах
-

Зөвлөмж:

- Сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой байдлыг суралцагч, ажил олгогч, төгсөгч нараас сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтанд тусгадаг байх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн хөтөлбөрийн дэд хорооны 2022 оны 11 сарын 01-ны өдрийн 03 дугаар хурлаар хичээлийн хөтөлбөрүүдийг хэлэлцүүлсэн. Хичээлийн хөтөлбөрийн сэдэвчилсэн төлөвлөгөө хэсэгт хичээлийн сэдэв, цогц чадамжийн харьцуулалтыг тусган хичээлийн төгсгөлд цаг ашиглалт, лекц үнших чадвар, үр өгөөж, дадлага, семинарын хичээлийг удирдан явуулах чадвар, шалгалтын материал хичээлийн агуулгатай тохирсон эсэх, хичээлийн явц, шалгалт шүүлгийн талаар оюутнуудтай эргэх холбоотой ажилладаг эсэх, шалгалт болон, шүүлгийн дүнг эргэн танилцуулдаг эсэх, багшийн хичээлд сэтгэл ханамжтай байгаа эсэх, багшийн ёс зүй, харилцаа хандлага, нэмэлт санал хүсэлт гэсэн нийт 10 багц асуулгаар оюутнуудаас судалгааг авч сайжруулалт хийдэг.
- Хичээлийн зохион байгуулалтаас хамааран лекц, дадлага, семинарын хичээлийн харьцаа ялгаатай байдаг бөгөөд 16 цагийн лекц 1 багц цаг, 32 цагийн дадлага, семинар 1 багц цаг, үүнд харгалзах бие даалтын цаг 48 байхаар сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг. Үүнээс үндэслэн онол, дадлагын харьцааг тооцон гаргасан бөгөөд 2016 оны сургалтын төлөвлөгөөний онол, дадлагын харьцаа 2016 оны төлөвлөгөөнд 48:6:51:4 байсныг 2020 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөг A/174 тоот тушаалд нийцүүлэн, хөтөлбөрийн үр дүн рүү чиглүүлэн сайжруулсан бөгөөд онол дадлагын харьцаа 34.7:65.3 болж өөрчлөгдсөн.
- Суралцах хугацаанд ерөнхий сувилахуй, төрөлжсөн сувилахуй, төгсөлтийн өмнөх 3 төрлийн дадлагыг 256 цагийн дадлагыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэдэг. Дадлагын удирдамжийг мэргэжлийн багш нар боловсруулан тэнхимиийн эрхлэгчээр хянуулан салбар сургуулийн захирал, төв сургуулийн сургалтын өмнөх бодлого зохицуулалтын газрын даргаар баталгаажуулан хэрэгжүүлдэг. Тайлангийн үр дүнг тайлан хамгаалалтын оюутны үнэлгээгээр дүгнэдэг.
- 1 болон 2 дамжааны дадлагыг Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэгт мэргэжлийн багш нарын удирдлаган дор тойролт хуваарийн дагуу хийдэг бол 3 дамжааны дадлагыг орон нутаг руу хуваарилан, албан бичиг хүргүүлэн хийлгэдэг.
- Хамтран ажиллаж буй эрүүл мэндийн газар, эмнэлгийн байгууллага нийт 16 бөгөөд 5 жил тутамд гэрээг шинэчлэн хийдэг.

- Хичээлийн хуваарийг Сургалтын өмнөх сургалтыг хариуцсан арга зүйч хичээлийн онцлогоос хамаарсан саналыг багш нараас авч, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн хуваарийг боловсруулан хичээлийн байрууд дээр цаасан хэлбэрээр байршуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Суралцагч нь суралцах хугацаандaa дамжаа бүрт нийт 8 багц цагийн, 256 цагийн дадлагыг хийж төгсдөг. Удирдамжийг тэнхим, мэргэжлийн багш нар боловсруулж, тэнхимиийн эрхлэгч, сургалтын хөтөлбөр хариуцсан арга зүйч нар хянан, сургалтын албаны дарга зөвшөөрснөөр, захирад баталж хэрэгжүүлдэг.
- “Мандах наран” түшиц эмнэлэгтэй бөгөөд хичээлийн бусад цагаар тухайн эмнэлэгтэй дадлагажих бүрэн боломжтой.

Анхаарах асуудал:

- Мэдээлэл зүйч, технологич байх чадамжийг хөтөлбөрийн үр дүн (PLO)-д тусгасан боловч сургалтын төлөвлөгөөний шинэчлэлд мэдээллийн технологи, мэдээллийн систем хичээлийг заавал судлах хичээлээс сонгон судлах хичээл рүү оруулсныг цаашид анхаарах

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөний 62 хичээлээс хөтөлбөрийн үр дүн болох цогц чадамжтай нийт 9 хичээл буюу нийт хичээлийн 14.5%-тай матриц хамаарлыг тооцон гаргасан нь хангалтгүй
- Хичээлийн агуулгын уялдааг 62 хичээлээс 4 хичээлээр тооцон гаргасан бөгөөд үүнийг нийт хөтөлбөрөөр гаргах
- Сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлүүд тусгагдсан боловч багшийг сонгох байдал хязгаарлагдмал
- Суралцагчийн цагийн ачааллыг өдөрт 8 цаг, 7 хоногт 40 цагаас хэтрэхгүй ачаалалтай байхаар тооцдог гэсэн боловч бодит байдал дээр оюутнуудын сургууль дээр байх ачаалал бага байгаа нь ажиглагдсан бөгөөд цаашид өдөрт 6-8 цагаар сургууль дээр байх ачааллыг тооцон сонгон судлах болон давтлага хичээлийг нэмэгдүүлэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтээ технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйг 2021 оны 01 дугаар сарын 28 өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам”-ын 2-р хавсралтын 3-р бүлгийн “Сургалтын арга, хэлбэр” заалтын дагуу хэрэгжүүлдэг. Мөн мэргэжлийн хөтөлбөрт лекц, дадлага, семинар, бие даалтын арга зүйг тусгасан. Сургалтын аргуудаас 10 төрлийн аргыг тусгасан. Хичээлийн хөтөлбөрт 3 ба түүнээс дээш арга зүйг тусгасан ба хэрэгжилт 1-р дамжааны 16 хичээлийн хүрээнд харилцаанд суурилсан арга 62.5 хувьтай, 2 дамжааны 15 хичээлийн хүрээнд асуудалт суурилсан арга 100%, 3 дамжааны 13 хичээлийн хөтөлбөрийн хүрээнд интерактив арга 84 хувь, асуудалд суурилсан, багаар ажиллах аргууд тогтмол ашиглагдаж байна. Давхардаагүй тоогоор нийт 62 хичээлийн хөтөлбөрт 26 арга зүй байна.
- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн захирлын 2022 оны 10 сарын 1 өдөр баталсан удирдамжийн дагуу 2022-2023 оны хичээлийн жилд багш нарын

дунд “Сурган заах арга зүйн” нээлттэй хичээлийн тэмцээнийг зохион байгуулдаг бөгөөд нээлттэй хичээлийн лекцийн төрөлд 1 улиралд 6 багш оролцсон. Цаашид хичээлийн жилийн турш хэрэгжих бөгөөд энэ багш нар арга зүйн туршлагаа хуваалцах боломж олгож байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд тонгоруу сургалтын арга болон цахим сургалтын аргыг нэвтрүүлж moodle, classroom-д хичээлийг бүрэн эхээр нь байршуулан нээлттэй байх боломжийг олгодог.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн цогц чадамжийг хэрхэн олгож байгаад анализ, дүн шинжилгээ хийгдээгүй
- Өөрийн үнэлгээний тайланда хийсэн ажлаа гүйцэд тусгах
- Хичээлийн хөтөлбөрт тусгагдсан арга зүй болон багш нарын хэрэгжүүлж буй арга зүйг судлан мэргэжлийн хөтөлбөрийн арга зүйг нэмэгдүүлэх
- Тайлан тусгагдсан мэдээлэл бодит байдал хоёр ялгаатай байгааг анхаарах
- Тайланд 2020-2021 оны хичээлийн жилээс тонгоруу аргыг хэрэглэж байгаа талаар тусгагдсан боловч багш нартай ярилцах явцад тухайн аргын талаар огт дурдаагүй
- Төгсөгч нараас лекцийг асуухаас өөр сонирхолтой аргаар явуулдаг байх мөн багаар ажиллах орчин нөхцөл бага байдаг үүнийг сайжруулах

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйн төрлийг нэмэгдүүлэн, хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, тогтмол сайжруулдаг байх
- Хөтөлбөрийн үр дүнг хангахуйц хөтөлбөрийн арга зүйг баяжуулах, орчин үеийн технологийн дэвшилтэд аргуудыг судлан сургалтандаа нэвтрүүлэн, хэрэгжилтийг үнэлэн, үр дүнг тооцон сайн туршлагаа хуваалцдаг байх

Шаардлага:

- Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтаар мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд 10 төрлийн аргыг ашиглаж байгааг нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн арга зүйн хэрэгжилтэнд анализ, дүгнэлт хийх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28 өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 1-р хавсралтын дөрөв дүгээр бүлгийн “Үнэлгээний аргачлал” хэсгээр зохицуулдаг. Сүүлийн 4 жилд 2017-2021 оны хугацаанд нийт 1448 суралцагчаас хичээлд тодорхой шалтгаанаар хангалтгүй үнэлгээ авсан дипломын суралцагчийн тоо 162 бөгөөд дахин судлахдаа өвчтэй болон чөлөөтэй тохиолдолд төлбөргүй судлах боломж олгодог.
- Хичээлд суугаагүй, унасан, багц цагийн зөрүүтэй тохиолдолд үндсэн багц цагийн төлбөрийг төлж судалдаг. Нөхөлт хичээлд хамрагдах оюутны нэrsийг сургалтын албанаас гарган мэргэжлийн тэнхимд хүргүүлэн тэнхимээс нөхөлтийн хуудсаа авч

дахин судлах хичээлд хамрагддаг. Цар тахлын үед төлбөргүй нөхөлт хичээлийн хугацааг зааж тэр хугацаанд хамрагдан судлах боломжоор хангасан.

- Хичээлийн хөтөлбөр бүрт үнэлгээний арга зүй тусгагдсан бөгөөд 1 дамжаанд аман шалгалт 80%, сорил 60%, эсээ 31%, гардан 25% хичээлийн онцлогоос хамааран ашигладаг. 2 дамжаанд асуумж, сорил 100%, гардан ажилбар 60%, 3 дамжаанд сорил 92%, гардан 53%, аман шалгалт 23%, тохиолдол ажиллах 23%-тай ашиглагдаж байна.
- Гардан үйлдэл бүхий хичээлүүдийн явцад оюутны бусадтай харилцах харилцаа хандлагыг оюутан өөрийгөө үнэлэх, хамтран суралцагч үнэлэх, багш үнэлэх 3 талт үнэлгээ бүхий 360 хэмийн аргыг хичээлийн явцад ашигладаг.
- АШҮҮИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28 өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 1-р хавсралтын дөрөв дүгээр бүлгийн “Үнэлгээний аргачлал” хэсгээр зохицуулдаг. Явцын үнэлгээ 70, шалгалтын үнэлгээ 30 байхаар тусгасан.
- Төгсөлтийн шалгалт болон улирлын шалгалтыг 4 хэлбэрээр болон А болон К хэлбэр 60:60 хувь, В болон Е хэлбэр сорил 15:15 хувь байхаар тусган хэрэгжүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хандлагыг 360 хэмийн үнэлгээгээр үнэлдэг.
- 2017-2021 оны хугацаанд нийт 74 төгсөгч төгссөн бөгөөд голч дүнгийн амжилт тогтолц өсөлттэй буюу 2.89-3.25 байна.
- Сүүлийн 5 жилд сувилах эрхийн лицензийн шалгалтанд 100 хувийн амжилт үзүүлсэн.

Анхаарах асуудал:

- Нотлох баримтаар I-III дамжааны үнэлгээний аргын 84 хувьд сорил ашиглаж байгаа боловч нотлох баримтаар сорилын нэгдсэн сангүй байгааг анхаарах
- Хандлагыг 360 хэмийн аргаар үнэлдэг талаар тайланд тусгагдсан боловч цөөхөн хичээлийн хүрээнд хэрэгжүүлж байгааг анхаарах
- Өөрийн үнэлгээний тайланд хийсэн ажлаа гүйцэд тусгах

Зөвлөмж:

- Сорилын нэгдсэн сантай болох ба сорилын сан, шалгалтын материал, үнэлгээнд дүн шинжилгээг тогтолц хийдэг байх

Шаардлага:

- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх нэгдсэн санг бий болгох
- Хөтөлбөрийн үнэлгээнд сорилд суурилсан үнэлгээ давамгайлж байгаа тул үнэлгээний аргачлалыг нэмэгдүүлэх
- Хичээлийн болон хөтөлбөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, багж хэрэгсэл, багшийн ажиллах орчин хөтөлбөрийн хэсэгт нотлох баримт жагсаалт байна. Үүнд: сургуулийн нийт талбай 4274м², эзэмшил газрын байршилын кадастрын зураг, сургуулийн план зургууд давхар бүрээр, оюутны хувцасны локерын зураг, анги танхимын үзүүлэлтүүд, цахим сургалт хийх орчин өрөө танхим, багш хөгжилийн төв, ур чадварын төвийн үйл ажиллагааны хангамж, хүрэлцээ, номын сангийн ажиллах журам стандарт, номын жагсаалтуудыг унших болон цахим хэлбэрээр ангилан хийсэн, номын сангийн үйл ажиллагааны тайлангууд зэрэг байна.
- Сургалтын үйл ажиллагаа явуулах орчины болон технологийн нөхцөл нь “Дээд боловсролын байгууллага байгуулахад тавигдах нийтлэг шаардлага” нормативыг хангасан байна. Одоо сурч байгаа 158 оюутан байна, нэг оюутанд ноогдох талбай хичээлийн төв байранд 2.53 м², хичээлийн хоёрдугаар байр 7.79 м², номын санд 1.56 м², байна. Нийт сургалтын өрөө-43, нэг ээлжинд 400 оюутан хичээллэх 1264 м² хичээлийн төв байр, 160 оюутан хичээллэх 1232 м² хичээлийн 2 дугаар байр, 4 давхар 570 м² барилга, Мандах наран-Оюутан түшиц эмнэлэг, 100 оюутны суудал бүхий номын сан, 260 оюутан амьдрах оюутны 1 дүгээр байртай, сургуульд сувилахуйн ангийн дадлага хийх өрөө-9, семинар хийх-1 өрөөтэй байна.
- Нэг багшид ноогдох талбайн норм 4 м² байх нормд хүрэлцээтэй байна.
- Сургуульд нийт 47 угаалтуур, нийт 45 суултуур, хувцас солих өрөө 4, нийт өлгүүрийн хүчин чадал 350-400 хүний хувцас өлгөх боломжтой байна. Мөн оюутанд зориулсан хувцасны шүүгээг хүрэлцээтэй байршуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуульд оюутны сурхан барилгын засвар, тоног төхөөрөмж сайтай байна.

Анхаарах асуудал:

- Багш, оюутан нарт зориулсан хөнгөлөлттэй эрүүл хоолны газартай болох, багш нарт зориулсан цайны өрөөтэй болох

Зөвлөмж:

- Үгүй

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын UNIMIS программыг багш, оюутан нар, лайв вебинаар хичээл ороход ашигладаг программ, classroom, Face group, E-learning систем ашиглаж байна.
- Е контент түвшинд боловсруулсан сургалтын материалд e-erdem e-learning системд аудио, видео, РР хичээлүүд, цахим шалгалтын материал бэлтгэн оруулах, цахим сургалт, цахим лекц, хэлэлцүүлэг хийх, цахим ном хүлээн авах зэрэг ажилуудыг хийж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүнд ширээ, сандал, шүүгээ, комьютер, дэлгэц, самбар, сургалтын муляж 25 (бүтэн биеийн муляж-3, хэсэгчилсэн муляж 22) эмнэлгийн ор, сувилагч тэргэнцэр, хагалгааны өрөөний хэрэгсэлүүд, угаалтуур зэрэг нь нэг өрөөний суудлын тоонд харьцуулахад сайн хангагдсан байна. Дадлагын өрөөний багаж тоног төхөөрөмжинд ариутгал цэвэрлэгээг журмын дагуу хийж байна.
- Сувилагч мэргэжилтэн бэлтгэх сургалтын удирдамж-5, журам-21 байна. Үүнээс сургалтын үйл ажиллагаатай холбоотой 8 журам болон бусад дүрэмүүд байна. Үүнд: Ерөнхий сувилахуйн дадлагын удирдамж, Төгсөлтийн өмнөх дадлагын удирдамж, Төрөлжсөн сувилахуйн дадлагын удирдамж, Сувилахуйн түгээмэл хэрэглэгдэр гардан үйлдлийн удирдамж, Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, Багшийн үйл ажиллагааг гүйцэтгэлийг тооцох журам, АШУҮИС-ийн сургалтын технологи чанарын хяналтын журам, АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, болон бусад үйл ажиллагаатай холбоотой дүрмүүдийг баримтлан ажиллаж байна
- Оюутны дотуур байр 250 ортоогоос одоо 223 оюутан, эрэтэй 51, эмэгтэй 172 амьдарч байна. Оюутны байранд номын сан бүхий хичээл хийх өрөө, эцэг эхийн уулзалтын өрөө, усанд орох душ эмэгтэй 3, эрэгтэй 3, хоол хийх өрөөтэй, өрөөнд 5 ш плитка, 1ш печь, 1ш хөргөгч, махны 3 том хөргөгч байна. Мөн дотуур байрны санал хүсэлт авах хайрцаг, мэдээллийн самбар зэргийг тогтмол ажиллуулж байна. Дотуур байр тохижилт сайтай, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээ сайтай байна. Оюутны амьдрах орчин сайн хагагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчин сайн хангагдсан байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурх бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сан MNS 5742:2019 –ийг баримтлан ажиллаж байгаа ба орчин, гэрэлтүүлэг, чийгшил, дуу чимээ нь стандартад заасны дагуу байна. Номын сангийн эх үүсвэр номын фонд болох сурх бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүл, гарын авлага зэргийн баяжилт сайн байна. Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандарт болох MNS574:2007-г баримтлан 247 м² талбайтай, 116 оюутны суудалтай, хэвлэмэл ном 17462, цахим хэлбэрийн 1120 гаруй номтой, 590

гаруй оюутан, 70 гаруй багш ажилчдад үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Боловсон хүчний хувьд номын сангийн эрхлэгч-1, фондын номын санч -1, уншлагын номын санч -2, орон тоонд магистр 1, бакалавр 1, зэрэгтэй 1 боловсон хүчинтэй байна. 2019, 2020, 2021 онуудад номын сангийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. (нотлох баримтаар) Харин 2022 онд сэтгэл ханамжийн судалгаа аваагүй.

- Сүүлийн 5-н жилд шинэ номын худалдан авалтанд 897 ширхэг мэргэжлийн, 283 ширхэг хандивын ном сурх бичигт 30145628 төгрөгийг зарцуулж, 44 нэр төрлийн 1442100 төгрөгний хэвлэлээр фондоо баяжуулсан. Нэг оюутанд ноогдох ном 29 байна.
- Номын фондыг хэлээр ангилахад монгол 20,060, орос 1827, англи 1827, нийт 23,073 номтой байна. Цахим ном нийт 1,417 иүүнээс монгол 376, англи 713, бусад хэл дээр 328 номыг уншигчдад хүргэж байна. Нэг оюутанд оногдох мэргэжлийн ном 17,3 байна.
- 2016 оноос Koha программ ашиглаж уг программд 12614 ном буюу нийт номын 75%-ийг электрон катологит шивж оруулсан. Номын сан нь 9 компьютер бүхий WI-FI төхөөрөмжтэй интернэтийн танхимаар үйлчилж байна. Цахим номын сан нь 1310 цахим ном, 1109 эрдэмийн бүтээлүүдийг <http://library.mnums.edu.mn/> хаягаар, унших боломжтой. Уншигчид library.support@mnums.edu.mn хаягаар захиалга өгч, цахим ном болон эрдэм шинжилгээний бүтээлүүдийг цахимаар унших боломжийг бүрдүүлж ажилласан. 2021 оны 01-11 сарын 15-ны байдлаар 1995 оюутан 4982 ширхэг цахим ном, 50 гаруй багш ажилтан 79 ширхэг цахим номыг цахимаар захиалан уншсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Koha программ ашиглаж байна, мөн ном ариутгагчийг 2016 оноос эхлэн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Номын сангийн цахим орчинг интернетийг сайжруулах

Зөвлөмж:

- Үгүй

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 2017, 2019, 2022 онуудад бүтцийг боловсронгуй болгож, Түшиц эмнэлгийг бие даасан алба болгосон ба Номын сан, мэдээлэл технологийн албуудыг нэгтгэх, хүний

нөөцийг тэнхимүүдэд жигд хувиарлах, хөтөлбөрийн дэд хороог бүтцэд оруулах зэрэг өөрчлөлтийг хийсэн байна.

- АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн санал дүгнэлтэнд үндэслэн Их сургуулийн захирлын тушаалаар Хөтөлбөрийн хороог байгуулсан бөгөөд уг хороо нь их сургуулийн хэмжээнд ажиллах ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн түвшинд ажиллах дэд хороо бүтэцтэй ажиллаж байна.
- Сургалтын үйл ажиллагаа, төгсөгчдийн талаар Эрүүл мэндийн байгуулагын удирдлага, ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авдаг бөгөөд судалгаанд хамрагсдын 42,8% нь сургалтын хөтөлбөрийг хангалттай, 43% нь дунд зэрэг, 14,2% хангалтгүй хэмээн үнэлсэн байна.
- Сувилахуйн дипломын хөтөлбөрөөр суралцаж сүүлийн 5 жил төгссөн сувилагчдын 70,9 хувь нь зүүн болон говийн бусийн 7 аймгийн (Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сүхбаатар) сумдад ажиллаж байна.
- Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэн 2016 онд гэрчилгээ гардан авсан.
- Гомдол шийдвэрлэх журмыг мөрдөж ажилладаг. Багш нартай холбоотой 6 гомдол, үйлчилгээний ажилтантай холбоотой 3 гомдол, оюутны бүртгэл мэдээлэлтэй холбоотой 56 гомдол ирж холбогдох арга хэмжээг авсан байна.
- АШУҮИС-ийн захирлын 2015 оны А/55 тушаалаар UNIMIS программыг ашиглаж байна. Удирдлагын мэдээлийн системүүдийг ашиглаж байна. Үүнд:
 - Удирдлага мэдээллийн систем /Monitor.xcloud.mn/
 - Суралцагч /Student-web.xcloud.mn/
 - Оюутан хариуцсан мэргэжилтэн /Main.xcloud.mn, Sts.elf.mn/
 - Багш /Teacher- web.xcloud.mn/
 - Элсэгч, төгсөгчид /hemis.edu.mn/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2020-2021 онд аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа нийт 37 эмч, сувилагч нар Магистрын зэрэг хамгаалсан ба үүнээс 23 нь сувилагч мэргэжилтэн байлаа. Магистрын ажлын судалгаа шинжилгээний ажил, боловсруулалт хийхэд тус сургуулийн эрдэмтэн багш нар арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажилласан.

Анхаарах асуудал:

- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэнд хийсэн дүн шинжилгээ хангалтгүй бичигдсэн байна.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ бичигдээгүй.
- Ирсэн 56 гомдлын дагуу авсан холбогдох арга хэмжээ тодорхойгүй.
- Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын гэрчилгээний хүчинтэй хугацаа 2021 онд дуусчээ.

- Хичээлийн жилийн I улирлын шалгалт дөхөж байгаа цаг үе гэхэд сургууль нам жим, олон оюутнууд хичээлгүй байна. Зарим өдөр оюутан 2 цагийн хичээлтэй байдаг байна.
- Тайланг бичихэд ороогүй тул мэдэхгүй байна гэсэн хариултууд гарч байна.

Зөвлөмж:

- ЭМБ-ын удирдлага, ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийж, тодорхой төлөвлөгөө боловсруулах, эргэх холбоо үүсгэх, үр дүнг мэдээлдэг байх
- Бие даалт, сонгон суралцах хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих

Шаардлага

- Цаашид өөрийн үнэлгээний тайланд хийсэн ажлаа гүйцэд тусгах, тайланг хамт олноороо хэлэлцэх, хүн бүрийн оролцоог хангах
- ISO чанарын удирдлагын тогтолцоог тууштай хэрэгжүүлэх, хугацааг сунгах талаар цаг алдалгүй ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөтэй ажиллах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Зүүн болон.govийн бүсийн 7 аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж эмч эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтыг ханган төгсөлтийн дараах сургалт, оюутны зуны үйлдвэрлэлийн дадлага хийж байна.
- Багш нар аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллаж нарийн мэргэжлийн тусламж үзүүлэхийн зэрэгцээ цар тахлын үед анхны тусгаарлан эмчлэх байрыг бэлтгэн шар, улаан бүсэд ажилласан байна.
- 4 улсын 10 их, дээд сургууль, олон нийтийн байгууллага, олон улсын 5 байгууллага, дотоодын их дээд сургуулиуд, нутгийн удирдлагатай хамтран ажиллаж төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн сургалтыг бааз Мандах наран-Оюутан түшиц эмнэлэг, мэргэжлийн тэнхимүүд, Аварга тосон амралтын газраар дамжуулан олон талт үйлчилгээг хүргэдэг.
- Японы Китасато, Шизуока, Жичи, Синдэй, Герман Номын Гүүр ТББ, ӨМӨЗО Хөх хот, Ордос Их сургууль гэх мэт гадаад хамтын ажиллагаатай сургуулиудад 21 багш суралцсан байна. “Багш солилцооны хөтөлбөрт”-ийн хүрээнд Япон улсын Китасато Их Сургуулийн Сувилахуйн сургуульд 2017, 2018, онд 4, Шизуока Их Сургуульд 4 багш, ӨМӨЗО-ны Ажил мэргэжлийн их сургуульд 1 багш сургалтанд хамрагджээ.
- Оюутан түшиц эмнэлэг иргэдэд чиглэсэн үзлэг, шинжилгээ хийдэг.
- 2022 онд Дорнговь Анагаахын Төгсөгчдийн Холбоо нэrtэйгээр байгуулагдан, төв, зүүн,.govийн бүсийн аймгуудад салбар хороо байгуулан ажиллаж байна.

- Говийн бүсийн 7 аймгийн төгсөгчид болон ЭМГ, НЭ, БОЭТ-ийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ хийсэн. Төгсөгч нарын чанар, цаашдын тулгамдаж буй асуудал, сургалтын хөтөлбөрийн агуулгад шинээр орох асуудлын талаар уулзалт хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулж, уг арга хэмжээнд 7 аймгийн нийт 20 гаруй удирдах ажилтан, 350 гаруй төгсөгчид оролцсон.
- Зүүн болон говийн бүсийн аймгуудын ЭМГ, НЭ-тэй хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж шаардлагатай сургалтын талаар санал авч ТДС-уудыг зохион байгуулж 1419 мэргэжилтэн хамрагджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шидэг гар клубын оюутнууд хэвтрийн өвчтэй хүмүүст сувилахуй тусламж үйлчилгээг хүргэж, 3D донор клубын оюутан, багш нар Дорноговь аймгийн Цусны салбар станцын цусны нөөцийг бүрдүүлж жилд 20 гаруй литр цус хандивлахын зэрэгцээ “Дусал цус-Дүүрэн амьдрал аяныг 2 дахь жилдээ зохион байгуулсан байна.
- Аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Говийн чоно” олон улсын үзүүлэх сургалтыг 2019 онд зохион байгуулсан.
- Гадаад хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Японы Kitasato сувилахуйн сургууль, Дорноговь АУС-н хамтарсан олон улсын оюутан солилцооны 14 хоногийн хөтөлбөрт анааахын оюутан Баярцэцэг, Оюунжаргал нар хамрагдсан байна /2020.02.22-03.05/, MICA – Японы зуучлалын байгууллагатай хамтран “Summer job” хөтөлбөр хэрэгжүүлж 4 оюутан Япон улсад зуны дадлага хийж, асрамжийн газарт цалинтай ажиллажээ.

Анхаарах асуудал:

- Орон нутгийн санхүүжилттэй, хамтарсан төслүүдийг хэрэгжүүлсэн тайлан мэдээнүүдийг нэгтгэн, нотлох баримт хэсэгт оруулах
- Мандах наран-Оюутан түшэц эмнэлгийн хэмжээнд халдварын сэргийлэлт хяналт, чанар, аюулгүй байдлыг хангах асуудал нэн сул байсныг анхаарах

Зөвлөмж:

- Мандах наран-Оюутан түшэц эмнэлгийн хэмжээнд стандарт, мөрдөгдөж буй тушаал шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж 14 эх үүсвэрээс төсвийг бүрдүүлж байна. Сургалтын төлбөр, оюутны байр, хичээл нөхөлт, бусад орлого, хүүгийн орлого нийт төсвийн 98,5%-ийг бүрдүүлдэг байна. Жилийн төсвийн төлөвлөгөөг АШҮҮИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулсны үндсэн дээр захиран зарцуулдаг. Нийт төсвийн 56,8-77,9% цалин хөлс, нийгмийн даатгалд зарцуулагддаг.

- Орон нутгийн дэмжлэгтэйгээр оюутны байрны бүрэн засварыг 232,324.537₮ -р хийжээ.
- Сувилахуйн хөтөлбөрт зарцуулагдах төсвийг тусгайлан гаргах боломжгүй талаар тайланд тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ганц их сургуулийн хувьд орон нутгийн дэмжлэгийг жил бүр тодорхой хэмжээгээр авдаг.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн хөтөлбөрт зарцуулагдах төсвийг тусгайлан гаргах боломжгүй
- Сувилахуй дипломын сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, багш нарыг чадавхижуулах, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулахад тодорхой хөрөнгө, зардлыг төсөвлөх

Зөвлөмж:

- Багш нар болон ажилчдын нийгмийн баталгаа, цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрүүдийг эрэлхийлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуй дипломын сургалтын хөтөлбөрөөр **108 оюутан** суралцаж байна.
- Сайншанд суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг” 2017 оноос хойш зохион байгуулан ажиллаж байна.
- Сургууль суртачилах зорилгоор бүсийн 7 аймгийн ЕБС-ийн хими, биологийн 29 багштай хамтран ажиллах гэрээ байгуулж, шавь нараа бэлтгэх, урамшуулал олгох ажлыг сүүлийн 3 жил зохион байгуулж байна.
- Бүсийн аймгуудын төгсөгчдийн дунд уулзалт сургалтыг зохион байгуулж, “Багш шавийн уулзалтыг зохион байгуулж, судалгааг аймаг, эмнэлэг тус бүрээр гаргасан.
- Зүүн болон Говийн бүсийн 7 аймгийн төгсөгчид болон ЭМГ, НЭ, БОЭТ-ийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ хийж, сургалтын чанар, цаашдын тулгамдаж буй асуудал, сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 аймгийн 20 гаруй удирдах ажилтан, 350 гаруй төгсөгчид оролцсон.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн төгсөгчид бүсийн аймгуудад Дорноговь-93%, Говьсүмбэр-92%, Хэнтий-87%, Өмнөговь-90%, Дорнод-80%, Сүхбаатар-89%, Дундговь-57%-байна. Мөн Улаанбаатар хотын 2,3 дахь шатлалын эмнэлгүүд, Налайх-37%, Багануур-40% тус тус ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Зүүн бүсийн болон.govийн бүсийн аймгуудыг олон арван эмнэлгийн мэргэжилтнээр хангаж байсан 60 жилийн түүхтэй, 1000 гаруй суралцагчтай байсан сургууль 500 гаруй оюутантай болсон байдалдаа бодитой дүгнэлт хийх

Зөвлөмж:

- Сувилахуй дипломын сургалтын хөтөлбөрөөр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр санаачлагатай ажиллах

Шаардлага

- Сургууль сурталчилах, сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, амжилттай ажиллаж буй төгсөгчдөө нийтэд таниулах, сургуулийн амжилт, ололтыг мэдээлэх зэргээр маркетинггаа өргөжүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Янсанжав нарын эмхэтгэсэн “Шинээр элсэгчдэд зориулсан гарын авлага”
- Сургуулийн албан ёсны холбоосуудыг ашигладаг.
 - www.mnums.edu.mn
 - <http://elearning.mnums.edu.mn>
 - <http://student-we.xcloud.mn>
 - <http://twidp.xcloud.mn>
 - <http://sodg.group.mnums.edu.mn>

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс цахим хуудсаар дамжуулан сургалт, оюутны үйл ажиллагаа, зөвлөгөө мэдээллийг зөвхөн тус сургуулийн төгсөгчид, оюутнууд орох боломжтой 4900 дагагчтай Фейсбууук групп ажиллуулдаг.

Анхаарах асуудал:

- Интернэт ашиглалт, Фейсбуукт оруулж буй мэдээллийн шинэчлэл, эргэх холбоо зэрэгт хяналт хийх, боловсронгуй болгох
- Тайланд холбоосуудыг дурдсан байна. Өөр мэдээлэл олж үзсэнгүй.

Шаардлага:

- Өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг хүргэж ажиллах, баримтжуулах
- Техник технологийн шинэчлэл, ашиглалтыг сургалт, сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолго:

- АШҮҮИС-ийн захирлын 2021 оны А/213 тоот тушаалаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ын тушаалуудыг үндэслэн хэрэгжүүлдэг. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд багтсан хөтөлбөрүүдээр элсэн суралцах оюутны хяналтын тоог АШҮҮИС-ийн удирдах зөвлөлөөс тогтоож АШҮҮИС-ийн захирлын тушаалаар баталж хэрэгжилтийг хангадаг. 2021 оноос сувилахуйн дипломын хөтөлбөр Боловсрол шинжлэх ухааны яаманд шилжсэнтэй холбоотойгоор элсэлтийн ерөнхий шалгалтын оноо тооцох хичээлийг хими, биологи, математик, физик, нийгмийн тухай мэдлэг, монгол хэл, англи хэл зэрэг хичээлүүдээс өндөр оноотой 2 хичээлийн онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлж, оюутан суралцуулах гэрээ байгуулснаар оюутны элсэлт баталгааждаг.
- 2020 оноос элсэлтийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулан dormogobi-anagaakh.mn веб сайтын элсэлт цэсний цахим бүртгэлээр хандаж бүртгүүлдэг болсон.
- Тус сургууль нь нийт 556 суралцагчтай бөгөөд үүний 158 нь дипломын хөтөлбөрөөр суралцаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан элсүүлэх үйл ажиллагааг журмын дагуу хүртээмжтэй, ил тод зарчмын хүрээнд тушаалаар батлагдсан элсэлтийн комисс цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулдаг.
- Шинээр элсэн орсон оюутнуудад 07 хоногт Удиртгал хичээлийг танхим болон цахимаар зохион байгуулж олон талын мэдээллийг олгодог. Үүнээс гадна “Оюутны гарын авлага”-ыг боловсруулан хүргэдэг.

Анхаарах асуудал:

- I-III дамжаанд нийт 158 оюутан суралцаж байгаа боловч 2022-2023 оны хичээлийн жилд 19 оюутан элсэн суралцаж өмнөх жилээс элсэгчдийн тоо буурч байгаад анхаарал хандуулах

Зөвлөмж:

- Элсэлт буурч буй шалтгааныг тодруулах судалгаа хийх, элсэх үеийн судалгааг авч элсэлтийн үйл ажиллагаандaa ашигладаг байх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолго:

- Анги удирдсан багшийг тэнхимиийн хурлаар хэлэлцэн баталгуулж томилдог бөгөөд дүгнэхдээ сургуулийн зүгээс зохион байгуулсан соёл хүмүүжил олон нийтийн ажил, арга хэмжээнд оролцсон оролцоо, хичээл нөхөлт, ангийн хурал, сургалтын төлбөр төлөлт зэргийг харгалзан оноо өгч үнэлдэг.
- Сургалт хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн мөрддөг бөгөөд оюутанд чиглэсэн тогтмол 22 ажлыг зохион байгуулдаг. Сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөөний дагуу оюутан хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн тэнхим, арга зүйч нар хамтран зохион байгуулж

үр дүнг жилийн эцсийн тайлангийн хурлаар хэлэлцүүлдэг. Үйл ажиллагааны талаарх төлөвлөгөө, тайланг 2018 оноос хойш тогтмол архивжуулдаг.

- Бусад аймгуудаас суралцаж буй оюутнуудыг дотуур байранд амьдрах боломжоор хангадаг бөгөөд сургуулийн дотоод журам, оюутны байрны журамд заасны дагуу оюутнуудад зөвлөн тусалдаг бөгөөд сүүлийн 5 жилд оюутны дотуур байранд 1056 оюутан хамрагдсаны 29.5 хувь нь сувилахуйн дипломын хөтөлбөрөөр суралцагч байна.
- “Мандах наран” оюутны түшиц эмнэлэгт дотуур байрны оюутнуудад эмэгтэйчүүд, дотор, дүрс оношилгоо, мэдрэл, сэтгэц зэрэг үзлэгт хамруулан цар тахлын үед сургуулийн захиргаа, Сайншанд сумын иргэдийн төлөөлөгчийн зүгээс хүнс, дархлаажуулах болон ариутгалын бодисын тусламж үзүүлэн, цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа явуулан ажилласан.
- Оюутны байрны журмыг жил бүр шинэчлэн батлуулдаг. Үүний дагуу ажлын төлөвлөгөөг жилээр батлуулан жилийн эцэст тайланг танилцуулан тайлангийн хурлаар дүгнэдэг.
- Яаралтай тусламж, Эм судлал, Шидэт гар, Оюутнуудын улаан загалмай, OB and GYN, Эмгэг судлаач, Хүүхэд судлаач клубүүд тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Үйл ажиллагаа нь тогтмолжсон, төлөвлөгөөг сургалтын алба батлан, үйл ажиллагааны тайланг тогтмол танилцуулдаг.
- Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ өгөх төвийг 2018 оноос эхлэн Дорноговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн Сувилахуйн тэнхимиийн эрхлэгч сэтгэцийн багш Д.Долгорсүрэн оюутнуудад сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажилладаг.
- MICA-Японы зуучлалын байгууллагатай хамtran “Summer job” хөтөлбөрийн хүрээнд япон улсад сурангaa ажиллахад 1 багш, 4 оюутан хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт, хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлд сургуулийн захиргаанаас хяналт тавьж шаардлагатай тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамtran ажилладаг.
- Оюутны асуудлыг хариуцсан арга зүйчтэй бөгөөд хөтөлбөрөөр элсэгч оюутнуудын бүртгэлээс төгсөлтийн баримт бичиг олгох хүртэлх бүхий л үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.
- Дотуур байранд оюутны тав тухтай, аюулгүй байх нөхцөлийг хангахаас гадна интернэт орчныг бий болгосон. Мөн хөдөө орон нутгаас эргэлтээр ирсэн оюутнуудын ар гэрийнхэнд зориулсан амрах өрөөг тохижуулан ашигладаг.

Анхаарах асуудал:

- Жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг гэсэн боловч сургалт, хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, төсөлт ажлыг нэмэгдүүлэх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамtran ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотуур байранд Байрны оюутны зөвлөлийг 7 оюутны бүрэлдэхүүнтэй ажиллуулдаг бөгөөд дотуур байрны төлбөрөөс 100 хувь чөлөөлдөг. 2023 оны хичээлийн жилд дотуур байрны зөвлөлийн даргаар дипломын хөтөлбөрийн 3-р дамжааны оюутан Θ.Мөнгөнтуяа болон гишүүдээр тус хөтөлбөрийн 5 оюутан ажиллаж байна.

- “АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн АУС-ийн оюутанд тэтгэлэг олгох журам”-ийн шаардлага хангасан оюутанд захирлын нэрэмжит “500,000” төгрөгийн тэтгэлэг олгож хэвшсэн. Сүүлийн 5 жилд сувилахуйн дипломын хөтөлбөрийн 8 оюутан захирлын нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан.
- Аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай ажилд зуучлах тал дээр хамтран ажиллаж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд дипломын мэргэжлийн 5 оюутныг хамруулсан.
- Сувилахуйн ур чадварын улсын анхдуугаар олимпиадад тэргүүн байр, Аюулгүй тарилга үзүүлэхэд оюутны чадвар сэдэвт улсын олимпиадад тэргүүн байр эзэлсэн бөгөөд сургуулийн захиргаанаас гарах зардал, томилолт олгож дэмжлэг үзүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны нийгэмлэг бүхий сайн дурын өөрөө удирдах байгууллагатай бөгөөд тэргүүн, анги хэлтсийн дарга нараас бүрддэг. Урлаг соёл хүмүүжлийн баг, эрдэм шинжилгээ технологийн баг, олон нийт хэвлэлийн баг, сонирхлын бүлгээс бүрдсэн 10 клубийн үйл ажиллагааг чиглүүлэн, дэмжин ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сайн дурын үйл ажиллагаанд хамрагдсан талаар тайланд дурдсан хэдий ч сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын талаар тайланд тусгагдаагүй

Зөвлөмж:

- Оюутнуудын хүрээнд хэрэгжүүлсэн сайн дурын үйл ажиллагаа тогтмол хэрэгждэггүй, түүнд тохирсон урамшууллын тогтолцоо бага

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 1-р сарын 28-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 6-р зүйлийн 6.1-6.6-р заалтыг тус тус үндэслэн шилжилт хөдөлгөөн хийгддэг. Сургалтын алба нь оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг нэгтгэн улирал тутамд сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулдаг.
- Хөтөлбөр хооронд шилжин суралцах оюутан “Багц цаг дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу хөтөлбөрийг Сургалтын алба дүйцүүлэн тооцдог.
- Сүүлийн 5 жилд жилийн чөлөө авсан оюутны тоо 22, жилийн чөлөөнөөс эргэн суралцсан оюутны тоо 10, хөтөлбөр сольж суралцсан оюутны тоо 10, өөр сургуулиас ирсэн оюутны тоо 8, сургуулиас гарсан оюутны тоо 23 байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сүүлийн 3 жилийн судалгааны үр дүнгээс харахад сувилахуйн дипломын хөтөлбөрөөр суралцагчдын шилжилт хөдөлгөөн 13.1 хувиас 38.4 хувь болж өсөх хандлагатай байгааг анхаарах

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөний судалгааг тогтмол хийж, шалтгааныг илрүүлэн хөтөлбөртөө тусгах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын тухай хуулийн 8.7, 12.1.6 дахь хэсэг, БСШУС-ын 2012 оны 1 тушаал, АШҮҮСИС-ийн дүрмийн 4.8.7, 4.8.8, 5.8 дахь заалт “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам’-ын 7.18.1, 7.19.1 дэх заалтуудын дагуу хэрэгжүүлдэг.
- Төгсөлтийн баримт бичиг болох диплом нь кирилл, уйгуржин, англи хэлбэрээр хэвлэгдэн нийт суралцах хугацааны үнэлгээ, голч дүн, улсын шалгалтын үнэлгээ зэрэг тусгагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн мэргэжлийн салбар зөвлөлийн хурлын шийдвэр, төгсөгчдөд диплом олгосон бүртгэлийн хуулбар, диплом болон дипломын хавсралтыг тогтмол архивжуулдаг.
- БШУЯ-ны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд төгсөгчийн хувийн мэдээлэл болон дипломын мэдээллийг бүрэн баталгаажуулж, улмаар E-Mongolia цахим нэгдсэн мэдээллийн санд бүртгэгддэг.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2014 онд Хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулан 5 жилийн хугацаанд хэрэгжүүлж, 2020 онд боловсронгуй болгон мөрдөж байна.
- Сувилахуйн хөтөлбөрийн сургалтанд үндсэн багш нарын 72,3%, эрдмийн зэрэг цолтой багш нарын 60% нь оролцож байна.
- Хот руу чиглэсэн нүүдэл ихэссний улмаас нэг багшид ноогдох оюутны тоо цөөрч 2021 оны байдлаар нэг багшид 6 оюутан ноогдож байна.
- Сувилахуйн хөтөлбөрийн хүрээнд багш нар ачааллын дагуу сургалтын оноогоо гүйцэтгэж байгааг дурдсан байна.
- Сүүлийн 5 жилд 157 багшид 20,175.691 ₮-ийн мөнгөн урамшуулалт олгожээ.
- Сувилахуй хөтөлбөрийн сургалтад 2017 оны байдлаар дэд профессор зэрэглэлд 1, ахлах багш 3, багш 28, дадлагажигч зэрэглэлд 2 багш ажиллаж байсан бол 2021 онд ахлах багшийн тоо буурсан ч дадлагажигч 2 багш магистрын зэрэг хамгаалан багш зэрэглэлд шилжсэнээр тус зэрэглэлийн эзлэх хувь 9-өөр өссөн үзүүлэлттэй байна.
- Багш нарын 99,6% магистраас дээш зэрэг цолтой.
- Дорноговь аймгийн Эмнэлэг магадлах комиссын гишүүнээр 1 багш, Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны гишүүнээр 2 багш, Дорноговь аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Шинжээчийн комиссын гишүүнээр 1 багш тус тус ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эмнэл зүйн багш нар ЭМГ-тай хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, мэргэжлийн уралдаан тэмцээнд шүүгчээр ажилладаг.
- Орон нутагт танигдсан мэргэжлийн өндөр ур чадвар бүхий Зөвлөх зэргийн 4 багштай.

Анхаарах асуудал:

- Багш нарын залгамж холбоо, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах
- Багш нарт олгосон урамшуулал, дэмжлэг, тэтгэлэг зэрэг судалгааны дүнгүүдийг оруулах тал дээр цаашид анхаарах

Зөвлөмж:

- Сувилагч бэлтгэх багшийн хомсдол үүсэх эрсдлийг тооцох, хүний нөөцийг зохистой бүрдүүлэх талаар төлөвлөгөөтэй ажиллах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг 2018 онд боловсруулан хэрэгжүүлснээр 15 багш мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдан нарийн мэргэжил эзэмшиж, 8 багш мэргэжлийн зэрэг ахиулж, 2 багш докторын зэрэг хамгаалан, 11 багш докторын сургалтанд хамрагдаж байна.
- “Багшийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг 2022 онд АШУҮИС-ийн захирлын тушаалаар батлуулан мөрдөж байна. Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажилладаг.
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан 9 багш, докторантурт суралцаж буй 2 багшид сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлж, тухайн жилийн цагийн ачааллыг зохицуулан цалинг бүтэн олгосон байна. Бүтээлийн 1 сарын цалинтай чөлөөг 2 багшид олгон, урьдчилсан хамгаалалт хийсэн 1 багшид цалингийн 50%, докторын зэрэг хамгаалсан 1 багшид 1 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосон.
- Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж Монгол-Япон эмнэлэгт мэргэжлийн дагуу 2 багш ажиллан туршлага судалжээ.
- Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэгч 10 багш сүүлийн 5 жилийн хугацаанд мэргэжил дээшлүүлэх, эзэмшүүлэх сургалтанд хамрагдаж, сургуулийн зүгээс сургалтын төлбөрийн 50% хөнгөлөлт үзүүлсэн. 13 багш 5 улсын 10 их дээд сургуультай танилцан туршлага судлан урт богино хугацааны сургалтанд хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 онд сувилахуйн хөтөлбөрт хичээл заадаг мэргэжлийн зэрэгтэй багш 11 буюу 32,3% байсан бол 2021 оны байдлаар 20 багш буюу 57,1% болж, 2017 онтой харьцуулахад 92,5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Анхаарах асуудал:

- Залуу багш нарын тоо нэмэгдэхийн зэрэгцээ багшлах чадвар, эмнэл зүйн мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх

Зөвлөмж:

- Сургалтын чанарт ахиц гаргах, төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, удирдан манлайлах, зохион байгуулах ур чадварыг дээшлүүлэх тал дээр шинэлэг ажлуудыг зохион байгуулах, сургалтын агуулгад тусгаж өгөх
- Багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн хөгжлийн бодлого2015-2024-д Судалгаанд суурилсан их сургууль болох зорилт тусгагдсны дагуу тус сургууль тэргүүлэх чиглэлээ Анаагаах ухааны боловсрол судлал, Говийн болон зүүн бүсийн аймгуудын зонхилон тохиолдох өвчлөл, өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох, бууруулах арга замууд хэмээн тодорхойлж 6 зорилтыг тусган ажиллаж байна.
- 2017-2021 онуудад олон улсын сэтгүүлд 3 өгүүлэл хэвлүүлжээ. Сургуулийн “Хөдөлмөрийн дотоод журам” -ийн дагуу багш нарын эрдмийн ажлыг дэмжиж хөнгөлөлт урамшуулалт олгодог байна, тухайлбал: (T2C Mongolia) сургалтанд хамрагдсан багш Даваачимэгт 4,123.860₮ төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. Сүүлийн 5 жилийн байдлаар ЭШ-ний зардалд 201,790.000₮ төсөвлөж, ЭШ хурал зохион байгуулахад 40,270.670₮ зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар 2022 оны байдлаар зохиогчийн эрх 5, шинэ бүтээлийн патент 4 авсан байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын эрдэм судалгааны ажлын үр дүнгээс бусад судлаачид ишлэл авч ашигласан үр дүн бага байна.

Шаардлага

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээс ишлэл авахуйц чансаатай ажлын тоог нэмэгдүүлэх
- Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд тавих, олон улсын сэтгүүлд нийтлүүлэх чансаа өндөртэй илтгэл, өгүүлэлийн тоог нэмэгдүүлэх, хэвлүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш хичээлийн жилд өөрийн үнэлгээний тайланг сургалт, ЭШ, мэргэжлийн үйл ажиллагаа 3 чиглэлээр бичиж жилд 2 удаа тайлагнадаг.
- Багшийн ажлын хавтас бүрдүүлэлтийг 6 бүлэг 39 үзүүлэлтийн дагуу хийж баяжуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Багшийн хавтасыг жигдлэх

Зөвлөмж:

- Лекцийн хичээлийн сэдэв тус бүрээр агуулгын хувьд нэгдсэн сан бий болгож, багш бүр өөрийн хавтаст багтаан ашигладаг байх
- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнд хийсэн дүгнэлтийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гаргах, биелэлтийг тооцож ажиллах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, үнэлгээ хийлгэн 2018 оны 07 сарын 06-нд гэрчилгээг гардан авсан ба ISO 9001:2015 хүчинтэй хугацаа 2018-2021 онд байна. Энэ хугацаанд ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлэх Байгууллагын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс БУМИ, БМИ-ийг 2018 оны 5 сараас 9-12-ны өдрүүдэд хийсэн ба энэ үнэлгээгээр “Бүрэн хангалттай” үнэлгээ авч 5 жилээр үйл ажиллагаагаа магадлан итгэмжлүүлсэн.
- БСШУЯСайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-аар хөтөлбөр шинэчилсэн.
- “Менежментийн удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын журам”-ын дагуу батлах аудит хийлгэн гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмшихийг зөвшөөрсөн.
- Сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015, MNS ISO/IEC 19011:2016, MNS ISO17021-1:2016 стандартуудыг хэрэгжүүлж ирсэн.

- Сургалтын хөтөлбөрийн оролцогч тал болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр 2 талын сэтгэл ханамжийн судалгааг авсан байна. (нотлох баримтаар) Хамгийн сүүлийн 2021 оны судалгаагаар ажил олгогч талууд өрөнхийдөө сургалтын чанар, гардан ур чадвар, харилцаа хандлагыг сайжруулах нь чухал байна гэжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтын ISO9001:2015 хөтөлбөрт дахин үнэлгээ хийлгэж сунгуулах
- Дотоод аудит хийж буй багш аудитор нарт хийсэн сард нь нэмэлт урамшуулал цалин олгож байх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Сургууль төгсөгчид нь.govийн болон зүүн бүсийн аймгуудын ЭМБ-ын боловсон хүчиний 70-80 хувийг бүрдүүлж байна. Сургалтын хөтөлбөрт өгсөн төгсөгчийн үнэлгээ: 72,3%-хангалттай, 20% нь дунд зэрэг, 7,7% нь хангалтгүй хэмээн үнэлсэн. Сургалтын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээгүүр байсан.
- Төгсөгчдийн карьерын өсөлтийг сүүлийн 4 жилээр үнэлэхэд төгсөөд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байдал эрс өссөн байгаа нь сувилагч мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх нь чухал байгааг харуулж байна. 2016, 2017, 2018 онд төгссөн сувилагч, сувилахуйн ангийн оюутнуудын дунд тус сургуулийг төгссөнөөс хойш ажил эрхэлсэн байдлыг авч үзвэл 89.5% мэргэжлийн чиглэлээр ажиллаж байна. 2021 онд 72,4 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж, 6,9 хувь нь дараагийн шатны сургалтанд, 27,6 хувь нь бусад салбарт ажиллаж байна.
- Ажил олгогч талаас сэтгэлд ханамжийн судалгааг 2017-2020 онуудад нийт 13 албан тушаалтанаас 3 бүлэг 15 асуулт бүхий судалгаа авсан байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргахад сургууль төгсөгчдийн эрэлт өндөр байгааг харуулж байгаа хэдий ч төгсөгчдийн сургалтын чанар, гардан ур чадварыг сайжруулах, харилцаа хандлагыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байна гэсэн сэтгэл ханамжийн судалгааны дүнд гарсан харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сэтгэл ханамжийн судалгааг урд онтой харьцуулан дүгнэж байх
- Төгсөгчдийн сургалтын чанар, гардан ур чадварыг сайжруулах, харилцаа хандлагыг одоо байгаа түвшингөөс дээшлүүлэх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- БМИҮЗ-өөр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг салбар сургуулийн хэмжээнд анх удаа хийлгэж байна.
- Төгсөгчид төгсөлтийн дараах мэргэжил олгох сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалт, багц олгох болино хугацааны сургалтуудад суралцах эрх бүрдсэн байна. (Дотор, өрх, нярай)
- Нийт багш нарын дэд профессор 4,7%, доктор 19,5%, магистр 98%, клииникийн профессор 9,5% тус тус хамгаалсан байна.
- Эмнэлгийн мэргэжлийн зэргийг ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг гэсэн 3 шатлалаар олгохыг ЭМ-ийн тухай хуулийн 2.1-д зааж баталсан байна. Нийт багш нараас зөвлөх зэрэгтэй 9,5%, тэргүүлэх, ахлах мэргэжлийн зэрэгтэй 30,9% байна.
- Хөтөлбөрийн үнэлгээнд оролцогч, сонирхогч талуудыг жигд татан оролцуулсан байгаа нь цаашид хамтын үйл ажиллагааг сайжруулах, чанаржуулан ажиллах боломж харагдаж байна.
- Үндэсний хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, суралцах боломж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үнэлгээнд магалдан итгэмжлэл хийлгэх ажлын бэлтгэл ажлыг сайтар хангах (Бэлэн байдал зэрэгт)

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

ШАЛГУУР		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	1	2		Хэсэгчлэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2	3		Хэсэгчлэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	3	1		Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			Бүрэн хангасан
		20	6		
Дүгнэлт		ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн “СУВИЛАХУЙ” дипломын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагыг **“ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Т.Алтанцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Г.Шүрэнмягмар

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Ю.Оюунзул

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилго, зорилт, хөтөлбөрийн үр дүнгийн нийцэл, уялдаа холбоог тодорхойлох - Хөтөлбөрийн үр дүн болох цогц чадамжийг сувилахуйн мэргэжлийн шаталсан хэлбэрт тохируулан боловсруулах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Орчин үеийн технологийн дэвшилтэд аргуудыг судлан сургалтандaa нэвтрүүлэн, хэрэгжилтийг үнэлэн, үр дүнг тооцдог байх - Сорилын нэгдсэн сантай болох ба сорилын сан, шалгалтын материал, үнэлгээнд дүн шинжилгээг тогтмол хийдэг байх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Багш, оюутан нарт зориулсан хөнгөлөлттэй эрүүл хоолны газартай болох, багш нарт зориулсан цайны өрөөтэй болох - Номын сангийн цахим орчин, интернетийг сайжруулах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - ISO чанарын удирдлагын тогтолцоог туштай хэрэгжүүлэх, хугацааг сунгах талаар цаашид ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөтэй ажиллах - Бие даалт, сонгон суралцах хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих - Оюутан түшэц эмнэлгийн хэмжээнд халдварын сэргийлэлт хяналт, чанар, аюулгүй байдлыг хангах, мөрдөгдөж буй тушаал шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, төсөлт ажлыг нэмэгдүүлэх - Шилжилт хөдөлгөөний судалгааг тогтмол хийж, шалтгааныг илрүүлэн хөтөлбөртөө тусгах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Сувилагч бэлтгэх багшийн хомсдол үүсэх эрсдлийг тооцох, хүний нөөцийг зохистой бүрдүүлэх талаар төлөвлөгөөтэй ажиллах - Багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх - Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн үнэлгээний магалдан итгэмжлэл хийлгэх ажлын бэлтгэл ажлыг сайтар хангах (Бэлэн байдал зэрэгт)
ШААРДЛАГА	
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа 2.2 Сургалтын арга зүй	<ul style="list-style-type: none"> - Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтаар мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд 10 төрлийн аргыг ашиглаж байгааг нэмэгдүүлэх

	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн арга зүйн хэрэгжилтэнд анализ, дүгнэлт хийх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа 2.3 Суралцагчийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> - Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх нэгдсэн санг бий болгох - Хөтөлбөрийн үнэлгээнд сорилд суурилсан үнэлгээ давамгайлж байгаа тул үнэлгээний аргачлалыг нэмэгдүүлэх - Хичээлийн болон хөтөлбөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Цаашид өөрийн үнэлгээний тайланд хийсэн ажлаа гүйцэд тусгах, тайланг хамт олноороо хэлэлцэх, хүн бүрийн оролцоог хангах - ISO чанарын удирдлагын тогтолцоог туштай хэрэгжүүлэх, хугацааг сунгах талаар цаг алдалгүй ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөтэй ажиллах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Сургууль суртачилах, сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, амжилттай ажиллаж буй төгсөгчдөө нийтэд таниулах, сургуулийн амжилт, ололтыг мэдээлэх зэргээр маркетингаа өргөжүүлэх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа	<ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээс ишлэл авахийц чансаатай ажлын тоог нэмэгдүүлэх - Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд тавих, олон улсын сэтгүүлд нийтлүүлэх чансаа өндөртэй илтгэл, өгүүлэлийн тоог нэмэгдүүлэх, хэвлүүлэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Багш нарын нэрс	тэнхим	Албан тушаал	Эрдмийн зэрэг, цол	Ажилласан жил
1	Ш.Отгонтuya	СШУТ	Химиин багш	Магистр	8
2	Дү.Батцэцэг	СШУТ	Биофизикийн багш	Магистр	22
3	Х.Удвал	ЭЗ Био-Анагаах	Морфологийн багш	Доктор	40
4	Ш.Энхмаа	ЭЗ Био-Анагаах	Молекул биологийн багш	Магистр	12
5	А.Нямдаваа	ЭЗ Био-Анагаах	Физиологийн багш	Магистр	15
6	Ц.Сарантуяа	ЭЗ Био-Анагаах	Лабораторийн багш	Доктор	37
7	М.Отгон	Сувилахуй	Эхийн сувилахуйн багш	Магистр	11
8	Д.Мөнхцэцэг	Сувилахуй	Сувилахуйн багш	Магистр	4
9	Т.Энхмягмар	Эмнэл зүй	Хүүхдийн өвчин судлалын багш	Магистр	17
10	Ч.Баярзориг	Эмнэл зүй	Гэмтэл согог судлалын багш	Бакалавр	4

II. Оюутнуудын нэрс

1-р дамжаа

№	Овог	Нэр	Регистр	Утас
1	Доржпүрэв	Ануударь	ЕЭ04250604	94709588
2	Талгатбек	Жанааргүль	НУ01270208	95228732
3	Адъяа	Нарансолонго	ЛМ04210701	95531280
4	Одхүү	Номин-Эрдэнэ	ЕБ02251805	89170518
5	Чинбат	Солонго	ЛД04310303	88229398
6	Нэргүй	Ганганцэцэг	ЖЖ02260804	80997882

2-р дамжаа

№	Овог	Нэр	Регистр	Утас
7	Түвшижаргал	Золзаяа	ЕС03220815	91221598
8	Очирхуяг	Норовсүрэн	ЗЙ98120208	94806820
9	Эрдэнэбат	Алтанзул	ЖЖ02221501	94246027
10	Ууганхүү	Дагиймаа	ЕЙ98061023	80945996
11	Саандар	Мягмарсүрэн	ЗГ86111108	89783638

3-р дамжаа

№	Овог	Нэр	Регистр	Утас
1 2	Ганболд	Сувд-Эрдэнэ	РС90010209	98514676
1 3	Мянганбаатар	Өүлэн	ЖГ90070963	89830613
1 4	Шаравдорж	Отгонсувд	ЗГ01271902	95326032
1 5	Нэргүй	Одхүү	ЖЮ02220512	86533530
1 6	Гангантөгс	Сансармаа	ЖН01261701	85359809
1 7	Энхочир	Болорцэцэг	ЖЛ94101701	91211213
1 8	Сүхбаатар	Цэндсүрэн	ЖЮ99070509	88587478
1 9	Мөнхжаргал	Түмэнхүслэн	ЖЛ02231708	94934807

III. Ажил олгогчдын нэрс.

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Утас
1	У.Энхбаяр	НЭ-ийн дарга	96646886
2	Д.Батцэцэг	ЭМГ Эмнэлгийн тусlamж х/д	96469966
4	Ю.Дэлгэрмаа	Дотрын ахлах сувилагч	96625797
5	Х.Шинэжаргал	НЭ-ийн ахлах сувилагч	86015460
6	Б.Даваасүрэн	Өрхийн ахлах сувилагч	96066566
7	Т.Сансардулам	Ачлал/ дарга	90909041
8	О.Уранчимэг	Агатова өрхийн эмнэлэгийн дарга	86298989
9	У.Ариун-Эрдэнэ	НЭ ГСА	89038899
10	Д.Мөнхзул	НЭ СБА	99128804
11	Д.Түвшинзул	БОЭТ ӨМА	99073855
12	Б.Алтантөгс	ЭМГ ДУА	99052973
13	К.Гульжан	НЭ ХЭА	93032333

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэр	Төгссөн он	Одоо ажилж буй байгууллага	Утасны дугаар
1	Эрдэнэбилэг Эрдэнэсувд	2017	Дорноговь нэгдсэн эмнэлэг амбулаторын дурангийн сувилагч	96292639
2	Сайнбилэг Цэцэгсүрэн	2019	Өмнөговь аймгийн эрчимт эмчилгээний мэдээгүйжүүлэлтийн тасгийн арга зүйч	89646690
3	Шинэбаяр Азжаргал	2022	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг яаралтай тусlamжийн тасагт сувилагч	94476700
4	Лхагва Мөнхцолмон	2022	Дундговь Их хэт сумын эрүүл мэндийн газрын сувилагч	88523057
5	Г.Хонгорзул	2022	Улаанбаатар хот Сор клиникийн эмнэлэгийн сувилагч	88662086
6	Отгонбат Лайжханд	2020	Дундговь аймгийн Баянжаргалан сумын сувилагч	88983881

7	Б. Дэлгэрмаа	2020	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг дотрын тасаг	88894542
8	О.Дэрчинсүрэн	2019	Гэмтлийн сувилагч	80151575
9	Б.Сугармаа	2017	Говьсүмбэр аймгийн сувилагч	99689382
10	О.Золжаргал	2019	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг гэмтлийн тасгийн сувилагч	80151575
11	Ц.Батгэрэл	2018	Хэнтий аймгийн ахмадын сэргээн засах	80080138
12	Цэрэндорж Батзаяа	2021	Сүхбаатар аймаг сувилагч	96795558

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**АШУУИС-ИЙН ДОРНОГОВЬ
АЙМАГ САЛБАР
АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ**

117-1 тоот байшин, Энхтайваны гудамж, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44105,
Утгафакс: (705) 2-21-01

Цахим шуудан: soddg@mnnum.edu.mn

Дэлж. №. 16 № 196


танай _____ -ны № _____ -т

Г МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН 7
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

“Сувилахуй” дипломын сургалтын хөтөлбөрийн
магадлан итгэмжлэлийн Шинжээчийн тайланг уншиж
танилцаад хүлээн зөвшөөрч байгааг мэдэгдэж байна.

Цаашид зөвлөмжийн дагуу сургалтын хөтөлбөрт
шинэчлэл хийж, анхаарч ажиллах болно.

ЗАХИРАЛ М.ОТГОНЧИМЭГ



Дэлж. №. 16 № 196